

# ХЭРЛЭН СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН 2023 – 2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛТЫН ТАЙЛАН

# СУРГУУЛИЙН ЕРӨНХИЙ ТООН ТАНИЛЦУУЛГА

## Багш, ажилчид




## Мэргэжлийн зэрэгтэй багш




## Боловсролын зэрэгтэй багш







## Нийт 382 сурагчид






# 1

## Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах

"AMJILT" платформ, ESIS.EDU.MN , "Medlee" цахим сургуультай хамтран ажиллаж, Pearson, Eduten нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүллээ.








2-р улирлын сүүлийн 2 долоо хоногт цахимаар хичээллэсэн.




- 11 багш 46 цагийн хичээл орсон. Суралцагчдын ирц 86% байсан.
- 10 багш 53 цагийн цахим, даалгавар өгч ажилласан. Суралцагчдын хичээлийн тэмдэглэл ирүүлсэн хувь 72% байсан.

### 1 Сургалт

Багш нарт цахим хичээл, контент бүтээхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор power point, filmora 10 программууд дээр ажиллах сургалт зохион байгуулсан. мөн aplus.mn сайт дээр байршсан онлайн хичээлүүдээс сурсан чадвараа ашиглан цахим ном бүтээсэн.

"Цахим хичээл, контент бүтээх" сургалтад 20 багш хамрагдсан.

### 2 Контент

- mathigon
- power point
- cup cat
- filmora 10
- wordwall



### 3 Даалгаврын сан

10-11-р ангийн суралцагчдыг medle цахим ангийн хичээлд хамруулсан. soril.eec.mn сайтын дасгал даалгавар ажиллах оролцоог нэмэгдүүлсэн.




### 4 Цахим хичээл

Багш нар өөрийн youtube сувагт цахим хичээл бэлтгэн байршуулсан.



4а О. Дүүрэнбаяр- 14 хоног цас зудад боогдсон. АУБ Б. Энхнайрамдал алсын зайнаас удирдаж сургалтыг хэвийн зохион байгуулсан.





- MATHIGON программ дээр цахим ном 2
- POWER POINT программ дээр цахим хичээл 15
- CUP CAT программ дээр 1
- FILMORA 10 программ дээр контент 5
- WORDWALL программ дээр сорил дасгал 4

Нийт 37 цахим ном, цахим хичээл, контент, сорил бүтээсэн.







SORIL.EEC.MN сайтад бага ангийн 163 сурагч, дунд ангийн 39, ахлах ангийн 16 сурагч хандаж дасгал, сорил ажилласан. Үүний үр дүнд суралцагчдын математик чадвар 7% ахисан байна.















# 2

## Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах




- ❖ Суралцагч бүрт зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан хичээллэсэн.
- ❖ Сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйн болон гадаад орчин бүрдүүлсэн.
- ❖ Түгээмэл загвараар бэлтгэсэн хэрэглэгдэхүүн ашигладаг.
- ❖ Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагаа
- ❖ Сурлагын ахицыг тооцон ажилладаг.



### СУРГАЛТ

Аймгийн ХБИХ, хүний хөгжил, ХХҮХэлтсийн мэргэжилтнүүдийг урьж багш, суралцагчид, эцэг эхчүүдэд тэгш хамруулан сургах боловсролын талаар сургалт хийлгэж, мэдээлэл өгсөн.



### ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Суралцагчдад ялгаварлан гадуурхагдаагүй мэдрэмж төрүүлэхийн тулд сурах бичгийн дасгалуудыг гүйцэтгэлийн 4-н түвшингээр ангилж, ээлжит хичээл дээр ялгаатай байдлаар ашиглуулдаг.



### "ОЙЛГОЁ, ХҮНДЭЛЬЕ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЬЕ"

Суралцагчид бие биеэ хүндэтгэн, тусалж, хамтран суралцах орчин бүрдсэн. Үүний үр дүнд хөгжлийн онцлог ялгаатай суралцагчид сэтгэл зүйн хувьд илүү нээлттэй, олон найзтай, өөртөө итгэлтэй болсон.







**Хоцрогдлыг арилгах төлөвлөгөө, давтлагын хуваарь гарган хэрэгжүүлж, хуваарийн дагуу 7 хоногт 4 цаг ганцаарчлан ажиллаж, хичээлээ бататгах давтлага өгдөг.**

Гүйцэтгэлийн түвшин



Танин мэдэхүйн түвшин



# ХҮҮХДЭД ГАРСАН ҮР ДҮН















ГСТ – р хичээллэдэг 5б ангийн суралцагч

**Эхийн эхний 3-4 өгүүлбэрийг ойлгон уншдаг**

**Самбар, сурах бичгээс хуулан бичдэг**

Цээжээр 2-3 үетэй үгийг бичдэг

**Дуурайн зурдаг**

**Өнгө ялган буддаг**

**Зааврын дагуу хайчлан наамал хийдэг**

**Усан будгаар уусган буддаг**

**Математик чадвар 8% ахисан**

**Монгол хэл хичээлийн чадвар 3% ахисан**





Үр дүн:

- хичээлийн идэвх оролцоо нэмэгдэж, өөрийн түвшний даалгавруудыг урам зоригтой ажилладаг болсон.
- Сэтгэл зүйн хувьд илүү нээлттэй, олон найзтай, өөртөө итгэлтэй болсон.

# СУРЛАГЫН ХОЦРОГДОЛ АРИЛГАХ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

## ЭЕШ-д бэлтгэх 80 цагийн давтлага

**ЭЕШ-ЫН ДАВТЛАГЫН ХУВААРЬ**

2023-2024 оны хичээлийн жил — 2024 оны 01-р сарын 10-наас 24 хүртэл

| № | Хичээлийн нэр | Багшийн нэр | ДАВАА 9:00-10:20 | ДАВАА 10:30-11:50 | ДАВАА 12:00-13:20 | МЯГМАР 9:00-10:20 | МЯГМАР 10:30-11:50 | МЯГМАР 12:00-13:20 | ЛХАГВА 9:00-10:20 | ЛХАГВА 10:30-11:50 | ЛХАГВА 12:00-13:20 | ПҮРЭВ 9:00-10:20 | ПҮРЭВ 10:30-11:50 | ПҮРЭВ 12:00-13:20 | БААСАН 9:00-10:20 | БААСАН 10:30-11:50 | БААСАН 12:00-13:20 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Математик | Ц.Өнөрдалгэр | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Нийгэм судлал | Б.Батзориг | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Физик | П.Энхцэцэг | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Хими, биологи | А.Адъяаням | | | | | | | | | | | | | | | |

Хуваарь гаргасан: Сургалтын менежер Б.Цэрмаа

## Гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтад бэлтгэх 100 цагийн давтлага

## Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах давтлага




## Төрөлжсөн олимпиад бэлтгэх 80 цагийн давтлага




А. Адъяаням
Rising contributor · April 16

4 сарын 15-нд 8а, 9а ангиудад гүйцэтгэлийн үнэлгээнд бэлтгэх давтлагыг биологийн хичээлээр хийлээ. 8а анги ирц 23-16. 9а анги ирц 15-10.



## Анги дэвших болон сургууль төгсөх шалгалтад бэлтгэх 93 цагийн давтлага, бага ангид 122 цагийн давтлага хийсэн. Нийт 475 цагийн нэмэлт танхимын давтлага хийсэн.

# 3

# Байгууллагын менежментийн төлөвлөлт, цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

Анхны зураглал

Бнзх: алсын хараа, зорилго, зорилтууд



Сургалт

Байгууллагын менежментийн загвар

МХБ

Жилийн ажлын төлөвлөгөө

Хэрэгжилт

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ- 2022 онд 70.53 2023 онд 74.36, / 3.83/ , Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 46.9

Сурагчдад тулгамдаж буй асуудлыг тодорхойлон гаргасан. Бага анги ойлгох чадвар, унших хурдыг нэмэгдүүлэх, дунд ангид – өөрийгөө илэрхийлэх, өөртөө итгэлтэй байдлыг нэмэгдүүлэх, ахлах ангид бие даах чадварыг нэмэгдүүлэх

НБГ- ын ахлах мэргэжилтэн зөвлөх багш, үндэсний ментор Б. Оюунбилэг, захирал Ц. Саранцэцэг нар давхардсан тоогоор 59 багш ажилтанд сургуулийн менежментийн чиглэлээр сургалт хийсэн.

Бага анги “Хамтдаа ахья, “Өөрийгөө нээхэд тань бид тусалъя”, “Өөрөөсөө эхэлье, зорилготой суралцъя”

Байгууллагын менежментийн төлөвлөлтийг жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтийг хагас жил тутамд ажлын хэсгээр үнэлэн гүйцэтгэлийг хангаң ажиллав.














Үндсэн шалтгаан

Үндсэн шалтгаан

# ХЭРЛЭН СУМЫН ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР

**АЛСЫН ХАРАА**

**Тогтвортой хөгжлийг дэмжигч, бие даан тасралтгүй суралцагч, үлгэрлэн манлайлагч, эх оронч иргэн**

**Хүүхдийн дүр төрх**

**Ойлгох чадвартай** / даалгаврыг бүрэн гүйцэтгэдэг, тунгаан боддог, дүгнэлт гаргадаг/

**Өөртөө итгэлтэй** / өөрийгөө таньж, хөгжүүлдэг, буруу зөвийг ялгадаг, үзэл бодлоо зөв илэрхийлдэг /

**Бие даах чадвартай** / өөрийгөө хөгжүүлдэг, бие даан суралцдаг, шийдвэр гаргах чадвартай/

**Төрийн бодлого**

Хамтын оролцоо, үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах

- Eduten, Pearson нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Мэдлэг цахим сургуульд хамрагдах

**Сургуулийн зорилго:**

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж, хамтын ажиллагаа оролцоог өргөжүүлж, тэдний хөгжил төлөвлөлт, сурлагын амжилт, чанарт ахиц гаргана

**Сурагчдад тулгамдсан асуудал :**

Сурагчдын уншаад ойлгох, бие даах, өөртөө итгэх итгэл, анхаарал төвлөрөлт сул байна. Гар утасны хэрэглээ их байна.

## Тэргүүлэх зорилтууд

**Зорилт 1.** Суралцагчдын шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх нэгдмэл агуулга бүхий үйл ажиллагаар нэмэгдүүлэх

**Зорилт 2.** Хүүхдийн онцлог чадвар, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан хөгжлийг дэмжих

**Зорилт 3.** Дотуур байрны хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжин, бие даах чадварыг нэмэгдүүлэх

**Зорилт 4.** Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжиж, МХТ- ийн ур чадвараа ахиулан цахим платформ дээр суурилсан нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх

**Зорилт 5.** Багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг 5-10%- иар ахиулах

**Орон нутгийн оролцоо дэмжлэг**

"Хүн болох багаасаа"хөтөлбөр, " Эрдэм" хөтөлбөр, " Нэг голын хүүхдүүд" төсөл, Дорнодын багш, Байгаль шинжлэл- 2023, " Монгол бичгээ сурья",ОНХС- ийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтууд

**Эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо дэмжлэг:**

Сургуулийн үйл ажиллагаа, хүүхдийн сурах, хөгжих, хамтран ажиллахад санал өгөх, хамтран ажиллах, АУБ, мэргэжлийн багш нартай эргэх холбоотой , сургуулийн ажилд оролцоотой байх, Хүүхдээ ойлгох, дэмжих, хүүхэд хамгааллыг тавьж ажиллах

**Зорилт 1**

Бага ангид STEAM сургалтаар инженерчлэл, загварчлал, математик сэтгэлгээг хөгжүүлэх, Мэтгэлцээн клубын үйл ажиллагаар тогтмолжуулах, сурагчдын асуудал шийдвэрлэх чадварыг нэмэгдүүлж, аливаа асуудалд дүн шинжилгээ хийх чадварыг хөгжүүлэх, шинжлэх ухааны дугуйлан тогтмол хичээллэх, эко клубээр дамжуулан сурагчдын шинжлэн судлах, эрэлт хайлт, дүгнэлт хийх чадварыг хөгжүүлэх

**Зорилт 2 .**

Багш бүр ялгаатай даалгаврыг онцлог ялгаатай сурагчдад үр дүнтэй хэрэгжүүлэх, хөгжлийн онцлог ялгаатай сурагчидтай АУБ нар дэмжин ажиллах хөтөлбөр хэрэгжүүлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр сурагчдын хийгдэшин хувь, оролцоо, онцлог давуу чадварыг нэмэгдүүлэх, хөгжил, хамгаалал, сурах арга барил, эрүүл мэндийг дэмжих

**Зорилт 3**

Гэрийн даалгаврын цагийг тогтмолжуулах, даваа гараг бүр минутын уншлага хийх / 1-6/,урлагийн наадам, залны цагийг тогтмолжуулах,гараас гарт хүлээлгэн өгч хэвших

**Зорилт 4 .**

Амжилт системийг сургалт, үйл ажиллагаанд нэвтрүүлэх, багш бүр сургалтад МХТ- ийг ашиглах, 4-р ангид Eduten, 5-р ангид Pearson нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх

**Зорилт 5 .**

Өглөөний уншлага, өгүүлбэртэй бодлого 4-5- р анги, судалгаат хичээлийг тогтмолжуулах, хөтөлбөрт анализ хийх, үр дүнг тооцох

**Шалгуур үзүүлэлтүүд:**

- Нэгж хичээлийн шалгалтаар сурагчдын 70-80 хувь нь ахисан байх
- Ойлгох чадвар, өөртөө итгэх, бие даах чадвартай хүүхэд 70-80 хувь
- Сургуулийн нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт 80- аас дээш хувь хэрэгжсэн байх

# МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙН БҮЛЭГ

- Уншсан номын тэмдэглэл хөтөлж, сургамжит санаа, чухал хэсгийг олж, үйл явдлыг дараалалаар нь зургаар илэрхийлж хэвшсэн.
- Унших эх болон өгөгдлийг дахин давтан унших хэвшсэн.
- “Номын богц” аян өрнүүлсэн.
- Өглөөний уншлага, минутын уншлага тогтмолжуулсан.
- Мэтгэлцээний клубээр дамжуулан ишлэл зохиох, зүйр үг, түргэн хэллэг, онч үг зохиох, оньсого таалгах, хип хоп дуу сонсох, эрдэмтдийн хэлсэн үгийг тайлах, тайлбарлах , сурагч бүр нэг минутын илтгэлийг боловсруулан илтгэж сурсан.
- Найрал дууны дугуйлангаар өөртөө итгэлтэй дуулах, дууны урын санг баяжуулах, зургийн дугуйлангаар будгийн техник ашиглан уран задгай сэтгэж, өнгө уусган будах аргад суралцан, бүтээлээ тайлбарлах чадвар ахисан.
- Бусадтай хамтран ажиллах, бие даан ажиллах, эрэл хайгуул хийх,нэгтгэн дүгнэх, судалгаа хийх чадварыг 3-12 хувиар ахиулсан.

## Бага анги

**“ХАМТДАА АХЬЯ”**

Хүүхдийн ойлгон унших үйлийг дэмжиж тэдний сурлагын ахиц амжилтад дэмжлэг үзүүлнэ.
МХБ-н ахлагч Г.Эрдэнэсүх багш ажилладаг.

***ГАРАА:***

**Унших хурд - 68.74%**

**Ойлгох чадвар - 56%**

**Төлөвлөсөн ажил-12**

**Гүйцэтгэл – 83%**

**Хүрсэн түвшин: унших хурд - 77.1% ойлгох чадвар - 61.6%**





## Дунд анги

**“Өөрийгөө нээхэд тань бид тусалъя”**

Сурацагчдын аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд чиглүүлнэ.
МХБ-н ахлагчаар А.Адъяаням багш ажилладаг.

***ГАРАА:***

**Өөрийн санаа бодлоо илэрхийлэх чадвар 39,3%**

**Төлөвлөсөн ажил-14**

**Гүйцэтгэл – 85%**

**Хүрсэн түвшин: Өөрийгөө илэрхийлэх чадвар 45 %**



## Ахлах анги

“Өөрөөсөө эхэлье, зорилготой суралцъя”

Суралцагчдын шийдвэр гаргах, мэдээлэл цуглуулах, нэгтгэн дүгнэх чадварыг нэмэгдүүлэх, бие даах арга барил эзэмшихэд дэмжлэг үзүүлнэ.
МХБ-н ахлагчаар Л.Дуламсүрэн багш ажилладаг.

***ГАРАА:***

**Бие даах чадвар 58%**

**Төлөвлөсөн ажил- 10**

**Гүйцэтгэл – 90%**

**Хүрсэн түвшин: Бие даах чадвар 63 %**








Eco-Schools






Дорнод 2-р сургууль
Top contributor Ganpuu Bymba · Dec 1, 2023
3а анги 12.1
+10
2
2 comments
Like
Comment
Send


ӨГЛӨӨНИЙ УНШЛАГА ХӨТӨЛБӨР
Эрдэнэсүх Гандорж · Mar 24
Дорнод 2дугаар сургууль 2а анги
You, Баянмөнх Хуслэн and 3 others
Love
Comment
Send
Share


Дорнод 2-р сургуулийн сурагч эцэг, эхчүүдийн нэгдсэн бүлгэм
Ganpuu Bymba · Nov 21, 2023
3а анги уншлага 11.20 уйл явдал зургаар илэрхийлэн зурж байна
+14
You and 8 others
2 comments
Like
Comment
Send
Share


НОМЫН БОГЦ




10,11-р ангийн бие даан ажиллах даалгавар
"Миний сонгосон мэргэжил"





ЗӨВЛӨХ БАГШИЙН СУРГАЛТ

БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СУРГАЛТ

БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ СУРГАЛТ

ҮНДСЭН СУРГАЛТ

МХБ-Н АЖИЛ

БШУГ ЗӨВЛӨХ ТУСЛАХ

ТУРШЛАГА СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХИЧЭЭЛИЙН АЖИГЛАЛТ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨЛТ, МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨРТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ











**Үр дүн:** Багшийн хөгжлийг дэмжсэн 9 төрлийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 167 багш ажилтан хамрагдаж, ажлын байрандаа хөгжин, багаар хамтран ажиллах, үйл ажиллагааг оношлох, үнэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, сайжруулах, манлайлах, зэрэг харилцаа хандлагыг эрхэмлэх, хичээлд ажиглалт хийн хэлэлцүүлэг хийх, дүгнэх, хөтөлбөрөө шинжлэх, бичиг баримт боловсруулах зэрэг чадваруудадаа ахиц гаргасан.

# СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨРТ ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙВ.

ДОРНОД АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 26 өдөр — Дугаар А/09 — Чойбалсан

Сургуулийн менежментийн хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх баг байгуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2023- 2024 оны хичээлийн жилийн "Сургуулийн менежментийн хөтөлбөрийн хэрэгжилт"- ийн I хагас жилийн үнэлгээ хийх багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний багийн ахлагч: Б.Цэрмаа /Багшийн хөгжил хариуцсан сургалтын менежер/

Гишүүд: М. Мөнхөө /Үнэлгээ хариуцсан сургалтын менежер/
Ч. Болор- Эрдэнэ /Сургуулийн нийгмийн ажилтан/
У. Жавзмаа /Нярав/
Э. Батчимэг /Дотуур байрны багш/

2. Сургуулийн хичээл, сургалтын төлөвлөлт, түүний хэрэгжилт, менежментийн хөтөлбөрт тусгасан төлөвлөгөөт ажлын хэрэгжилтийг чиглэл бүрээр үнэлэн, дүгнэлтийг 02 дугаар сарын 29- ний өдрийн дотор сургуулийн захиралд танилцуулахыг үнэлгээний багийн ахлагч / Б.Цэрмаа/, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ Ц. САРАНЦЭЦЭГ

2024.02.26 №А/09
Хэвлэх хэрэгсэл №07 Х.Болортуяа

D:/My documents: tushaal-2024

1. Сургалтын хөтөлбөр, төлөвлөлт, цахим журнал хөтлөлт
2. Хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөө
3. Сургалтын аюулгүй орчин бүрдүүлэлт
4. Хүүхэд хамгаалал
5. Хүүхдийн хөгжил, хичээлээс гадуурх үйл ажиллагаа
6. Анги удирдсан багшийн үйл ажиллагаа
7. Эцэг эх, асран хамгаалагч нартай ажилласан байдал
8. Багшийн хөгжил
9. Ажлын хэсэг, оролцооны байгууллага

## БАГШ АЖИЛЧДЫН ҮНЭЛГЭЭ

**Дүгнэгдвэл зохих: 41**
**Дүгнэгдсэн: 41**
- 90% - 100% үнэлэгдсэн 6
- 80% - 89% үнэлэгдсэн 7
- 70% - 79% үнэлэгдсэн 14
- 60% - 69% үнэлэгдсэн 8
- 59% ба түүнээс доош үнэлэгдсэн 6

## ЗАСАН САЙЖРУУЛАЛТ

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн бага ангийн багш Л.Ганчимэгийн сургуулийн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ

2024.03.13

Багш Л.Ганчимэг нь 1а ангийг даан ажилладаг. Монгол хэл, Математик, Хүн ба орчин, Дүрслэх урлаг, Монгол ёс хүмүүжил хичээлүүдийг ордог. Багш зохицуулах цагаар сурагчдын унших чадварыг дэмжин ажилладаг.

| № | Үзүүлэлт | Авбал зохих | Авсан оноо | Дүгнэлт, өгсөн зөвлөгөө | Засан сайжруулсан байдал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Багшийн хичээлийн хөтөлбөр, төлөвлөлт | 5 | 3 | Багш ангидаа 6 төрлийн судлагдахууны хичээл заадаг. Багш жилийн төлөвлөлт гүйцэд хийсэн. Ээлжит хичээлүүдийн төлөвлөлт дутуу байна. Амжилт систем дээр цахим журнал хөтлөлт 1-р улирал 7%, 2-р улирал огт нөхөөгүй. **Зөвлөгөө:** Цахим журналаа гүйцээн нөхөж, цаашид өдөр бүр тогтмол нөхөж байх. Судлагдахуун бүрээр улирлын төлөвлөлтийг гаргаж, суралцахуйн үр дүнг тусгах, | |

| № | Багш нарын нэрс | Сургалтын төлөвлөгөө: Жил | Улирал | Нэгж | Ээлжит | Цахим журнал | Хоцрогдол: төлөвлөгөөтэй эсэх | хоцрогдсон сурагчтай ажилласан байдал /гарааны үнэлгээ, давтлага, ахиц, үр дүн/ | Сургалтын аюулгүй орчин бүрдүүлэх | Сургууль, дотуур байр дахь хүүхэд хамгаалал | Хүүхдийн хөгжил, хичээлээс гадуурх үйл ажиллагаа | АУБ үйл ажиллагаа | Эцэг эх, асран хамгаалагчтай ажилласан байдал | Багшийн хөгжил: Багшийн хөгжлийн төлөвлөгөө, тайлан | Мэргэжлийн хөгжлийн бүлэг | Зэрэгтэй багш нарын манлайлал | Ажлын хэсэг | Нийт оноо, хувь | Тайлбар, анхаарах асуудал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оноо | 5 | | | | | 1 | 4 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 3 | 4 | 3 | 5 | 50 | |
| 1 | Л.Ганчимэг | | | | | | | | | | | | | | | | | | |

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн бага ангийн багш Б. Энхнайрамдалын сургуулийн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ

2024.03.13

Багш Б.Энхнайрамдал нь 4а ангийг даан ажилладаг. Монгол хэл, Математик, Хүн ба байгаль, Хүн ба нийгэм, Эрүүл мэнд, Дүрслэх урлаг, Монгол ёс хүмүүжил хичээлүүдийг ордог. Багш зохицуулах цагаар сурагчдын ойлгон унших чадварыг дэмжин ажилладаг.

| № | Үзүүлэлт | Авбал зохих | Авсан оноо | Дүгнэлт, өгсөн зөвлөгөө | Засан сайжруулалт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Багшийн хичээлийн хөтөлбөр, төлөвлөлт | 5 | 3 | Судлагдахуун бүрээр жил болон улирлын төлөвлөлттэй. Нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр дутуу, албан бичгийн шаардлага хангаагүй. Цахим журнал хөтлөлт 1, 2-р улиралд ирц багшийн тэмдэглэл нөхсөн. Зарим хичээлийн багшийн тэмдэглэл дутуу байна. 3-р улирлын цахим журнал нөхөж эхлээгүй. **Зөвлөгөө:** Цахим журналаа гүйцээн нөхөж, цаашид өдөр бүр тогтмол нөхөж байх. Судлагдахуун бүрээр нэгж ээлжит хичээлийн хөтөлбөр засах, нөхцөл, гүйцэтгэл, шалгуурыг тодорхой болгох, нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр батлуулах | Цахим журнал: [illegible] 3-р улирал [illegible]. Хөтөлбөр төлөвлөгөө [illegible] - [illegible] - [illegible] 4 |
| | | | | Хоцрогдол бууруулах төлөвлөгөө байхгүй. Гарааны үнэлгээг монгол хэл, математик, хүн ба байгаль хичээлүүдээр хийсэн. Хоцрогдсон сурагчдад давтлагын хуваарийн | - Хоцрогдол бууруулах [illegible] |






**Үр дүн:** Байгууллагын менежментийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ахиулсан.

# 4

## “Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх

**Тэргүүлэх багшийн манлайлал- 8 багш**

**ЗОРИЛГО**

Багш нарын манлайллыг нэмэгдүүлэх, арга зүй, ур чадвар, шинэ санаа, бүтээлч туршлагыг түгээх /32 багш ажилтныг хамарсан./

**Үзүүлэх хичээл**

- Багш Б. Энхнайрамдал 5- р ангид “ Сэтгэлийн тэвчээр” сэдвээр ИЁЗБ хичээл
- Багш А. Адъяаням 6- р ангид “ Лакмусын цаас ашиглан бодис материалын хүчиллэг, суурилаг шинжийг турших сэдэвт хичээл
- Математикийн багш П. Отгонцэцэг 7- р ангид “ Монголын уламжлалт нэгж” сэдвээр хичээл заав.

**Сургалт зохион байгуулах**

- Багш Л.Оюунтунгалаг “Сурагчдын ялгаатай түвшинг хичээл төлөвлөлтөд тусгасан арга зүй”
- Багш С.Ариунбат “Тэгш хамруулах боловсрол”
- Багш Б.Батзориг ”Багш зөв хандлагыг эрхэмлэх нь”
- Багш Г.Эрдэнэсүх “Цахим контент бэлтгэх арга зүй”

**Контент хийх**

- Бага ангийн
- цахим ном 1,
- контент 2
- Биологи 1
- Орос хэл 1
- Түүх 1

**Үр дүн**

Туршлага, арга зүйгээ түгээж, манлайллаа нэмэгдүүлсэн. Сурагчдын оролцоог хангасан хичээл зохион байгуулах арга зүйг түгээсэн.








**Зөвлөх багшийн манлайлал- 1**

Сургалт, зөвлөх үйлчилгээ, үндэсний бичгийн уншлага, менежментийн хөтөлбөрийн танилцуулга, хичээлд ажиглалт хийх чиглэлээр ажиллаж 183 багш удирдлага хамрагдсан.

1,2,Булган сумын ЕБС, Гурванзагал сумын ЕБС, Хэрлэн сумын ЗДТГ-ажилтнууд багш нар

Үр дүн: Туршлагаа түгээн дэлгэрүүлж, багш нарт дэмжлэг үзүүлсэн.







# 2 дугаар бүсийн сургуулиудын хамтын ажиллагаа

## Сургалт

“Сургуулийн менежмент хамтын оролцооны үр дүн” сэдэвт үйл ажиллагааны хүрээнд зохиогдсон 6 чиглэлийн сургалтад 4 багш ажилтан хамрагдав.



## СХУ- Илтгэлийн уралдаан



БУЗАН-ийн багш нарын хамтран бичсэн “Хамтын хүч, зөв хандлага нь сургуулийн менежментэд эерэгээр нөлөөлөх нь” сэдэвт илтгэлээр оролцож бүсдээ түрүүлж, 1 дүгээр байр, аймагт амжилттай оролцсон.

## Хичээлийн хэлэлцүүлэг

6 судлагдахууны үзүүлэх хичээл, хэлэлцүүлэгт 6 багш оролцов. / математик, мэдээлэл зүй, уран зохиол, биологи, ИЁЗБ, биеийн тамир /



## Нэгж хичээлийн хөтөлбөрийн уралдаан



6 судлагдахуунаар 6 багш уралдаанд оролцож, биологийн багш А. Адъяаням ““Цусны эргэлтийн эрхтний байрлал, гадаад бүтэц” сэдвээр 1-р байр , багш С. Ариунбат биеийн тамир судлагдахуунаар 2-р байр эзэллээ.

## Төслийн шүүгчийн солилцоо

Бага ангийн багшийг дэмжих төслийн 2- р шатны уралдаан бүсийн сургуулиудын сургалтын менежерүүд харилцан шүүгчээр ажиллав.



Ахмад багшийн зөвлөх үйлчилгээ

2 төрлийн үйл ажиллагаанд 44 багш ажилтан хамрагдсан.

Ахмад багш Ж. Ганчимэг “Хүүхэд нэг бүртэй ажиллаж,сурлагын ахиц, амжилтыг дэмжих нь” сэдвээр сурлагын ахиц, хөгжлийг дэмжих сэдвээр туршлагаа түгээсэн.

Ахмад багш Г. Ганчимэг залуу багш нарт математик судлагдахуунаар үзүүлэх хичээл зааж, багш Ё. Ирина багш ажилчдад сургуулийн түүхэн танилцуулга хийлээ

Аймгийн ахмад багш нарын холбоотой хамтран ногоон байгууламжаа нэмэгдүүллээ.












Үр дүн:

- Залуу багш нар туршлага судалж, сургуулийн түүхэн замналтай танилцсан.
- Эко ногоон орчин бүрдсэн

# 5

## Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

Багш, ажилтныг стрессээс сэргийлэх, эерэг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор “Сэтгэл зүйн тренинг”, “Харилцааны 5 чадвар” сэдвээр сэтгэл зүйчийн сургалтыг зохион байгууллаа.

"Байгууллагын соёл" сургалтыг Отгонтэнгэр их сургуулийн багш Туяа явууллаа. Байгууллагын цахим групп дээр сэтгэл тайвшруулах аялгуу сонсгох, сэтгэл зүйчийн подкастуудыг байршуулсан.

Багш, ажилчдын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх зорилгоор спортын тэмцээн зохион байгууллаа.

Багш, ажилчдын 0- 17 насны хүүхдэд зориулан байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс “Хүүхдийн өрөө”-г тохижуулан өгч , багш, ажилчдыг ажилтай үед нь хүүхдүүдэдээ санаа зовохгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлсэн.

Үйлчилгээний ажилтны “ Хишиг өдөр” – ийг уламжлал ёсоор зохион байгууллаа.

Дотоод журамд ахмад багш ажилтанд дэмжлэг үзүүлэх заалтыг шинээр хэлэлцэн баталж, гавьяаныхаа амралтад гарахад үзүүлэх тусламж дэмжлэгийг үзүүлж байна. Энэ хугацаанд 4 ажилтанд хамт олон нь хүндэтгэл үзүүлж үдэж өгсөн.

**Үр дүн:** Багш, ажилтан стрессээ зөв тайлах, бие биендээ эерэг үг, урам өгч сурах талаар мэдлэгийг өгсөн. Ажлын байрандаа сэтгэл тайван ажиллаж байна.










6

. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох

Тус сургуулийн хүүхэд хамгааллын баг нь 7 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хүүхэд хамгааллын чиглэлээр 26 ажлыг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийт 43 багш, ажилтантай хүүхэд хамгааллын ёс дүрэм, нууцын гэрээг баталгаажуулсан. Үйл ажиллагааныхаа хүрээнд хүүхэд хамгааллын мэдээллийн самбар, сургуулийн 1, 2-р давхарт хүүхэд, багш, ажилтан, эцэг эхчүүдийн санал хүсэлтийг авах саналын хайрцгийг ажиллуулж байна.

Сургуулийн орчны аюулгүй байдалд жилд 2 удаа хяналт тавьдаг ба эрсдэлтэй гарсан зөрчлийг тухай бүр холбогдох хүмүүст мэдэгдэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч байна. Сургуулийн хашаанд нийт 8 траншейны нүх байдаг ба бүгд тагтай, нүх шуудуу байхгүй, ил цахилгааны утас байхгүй, биеийн тамирын талбайн чийрэгжүүлэлтийн хэрэгсэл бүрэн бүтэн байна.

Сурагчдыг аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Чи ганцаараа биш”, “Хамтдаа шалгая хамгаалья”, “Харилцан хүндэтгэе”, “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” аяны хүрээнд нийт 16 сургалт, үйл ажиллагаанд 1-12-р ангийн давхардсан тоогоор 774 сурагч хамрагдсан.

“Эцэг эх зохицуулагч” арга хэмжээнд 85 эцэг эх, асран хамгаалагч нар эргүүлд гарсан ба 1-5-р ангийн 198 сурагчдад замын хөдөлгөөний “Тото Лулугийн адал явдал”, “Замын хөдөлгөөн”, “Анхаар 1” видео бичлэг, 9-12-р ангийн 89 сурагчдад “Насанд хүрээгүй хүүхдийг машин, мотоцикл жолоодуулахгүй байх" талаар санамж гарган танилцуулан, баталгаажуулсан. Замын цагдаагийн газраас “Замын хөдөлгөөнд зөв оролцох, эцэг эх зохицуулагч нарын анхаарах асуудал" сэдвээр 21 эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулсан.

Хүүхэд хөгжүүлэх дугуйланд давхардсан

тоогоор

451 суралцагч сурч байна.

Хүүхэд хөгжүүлэх 8 төрлийн дугуйланд нийт 198 суралцагч сурдаг.

Хүн болох багаасаа төслийн 7 төрлийн дугуйланд нийт 253 суралцагч сурдаг.

Өсвөрийн цагдаа бүлгэм

Охидын клуб

**Эко ногоон дэлхий клуб**

**Өсвөрийн эмч клуб**

Сурагчдын өөрөө удирдах зөвлөл

Мэтгэлцээн клуб



Энэ хичээлийн жилд дээрх 6 байгууллагад 98 суралцагч ажилладаг ба нийт 13 ажил зохион байгуулж 239 суралцагчийг хамруулсан.

Үүнд:

- Мэтгэлцээний тэмцээн
- Гоо бичигтэн уралдаан
- Эко булан тохижуулах
- Хуванцар савыг хэрэглээ болгох
- “Усны өдөр”
- Угтах үйлчилгээ
- Завсарлагааны цагаар эргүүл хийх
- Цүнх арга хэмжээ
- Ангийн ариун цэвэр
- Хүмүүнлэгийн ажлуудад оролцох

“Эцэг эх зохицуулагч” арга хэмжээнд 85 эцэг эх, асран хамгаалагч нар эргүүлд гарсан.
“Тото Лулугийн адал явдал”
“Замын хөдөлгөөн”
“Анхаар 1”

1-5-р ангийн 198 сурагчдад замын хөдөлгөөний видео бичлэг

“Насанд хүрээгүй хүүхдийг машин, мотоцикл жолоодуулахгүй байх" талаар санамж гарган танилцуулан, баталгаажуулсан.

9-12-р ангийн 89 сурагчдад

Замын цагдаагийн газраас “Замын хөдөлгөөнд зөв оролцох, эцэг эх зохицуулагч нарын анхаарах асуудал" сэдвээр эцэг эхэд сургалт зохион байгуулсан.

41 эцэг эхчүүдэд сургалт














# Байгууллагын орчны эрсдэлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Цаашид анхаарах:

- ✓ Камержуулалт шинэчлэх



Байгууллагын дотоод хяналт нэгж нь нийгмийн ажилтан Ч.Болор-Эрдэнэ ахлагчтай 3 бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Нийт 10 ажил төлөвлөөд 8 ажлыг хийж гүйцэтгэсэн. 2023 оны сүүлийн хагас жилд 6 ажил, 2024 онд 2 ажлыг хийсэн.

“Дотуур байр, сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах” үнэлгээг 5 үзүүлэлт 143 асуулгаар хийж, сургуулийн зүгээс Шинь Шинь ХХК-д ачаа тээврийн битүүмжлэлийн асуудалд анхаарах, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хөрсний шинжилгээ хийлгэх тоотыг хүргүүлсэн байна.



Сургуулийн захирал, дотоод хяналтын нэгжтэй хамтран 10 анги, 5 танхимын эд хогшил, гэрэлтүүлэг, аюулгүй байдалд эрсдлийн үнэлгээг хийж, ширээ сандлын эвдрэл, гэрэлтүүлгийн бүрэн болгох, хөшиг хийх, өлгүүр хийх зэрэг зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өгч дахин шалган зөрчлийг арилгууллаа.

**Үр дүн:** Дотоод хяналтын нэгжээс 8 удаа хяналт үнэлгээ хийж эрсдлийг бууруулж ажилласнаар БШУГ, ЭМГ-аас хийсэн шалгалтад бага эрсдэлтэй гарсан.

## Онцлог ажил, бидний амжилт, хөрөнгө оруулалт

- Эко сургууль хөтөлбөрийг 2016 оноос хойш тасралтгүй хэрэгжүүлсэн. 2024 онд 3 дахь “ Ногоон туг “, алтан гэрэгэ авсан.
- Тус хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахын тулд аймгийн бусад байгууллагатай хамтран ажилладаг. одоогоор Хэрлэн сумын 1-р цэцэрлэг, 8- р сургууль, ШШГГ, аймгийн ахмад багш нарын холбоотой хамтран ажилласан.
- Хүүхэд багачуудад эх дэлхийгээ хайрлах сэтгэлийг багаас нь төлөвшүүлэх зорилгоор “Ногоон дэлхий Эко клуб” -ын үйл ажиллагааг идэвхжүүлдэг.
- Хүүхэд хөгжих аюулгүй, эко орчин бүрдүүлэхэд багш, суралцагч бүр санаачилгатай ажиллаж, сургуулийн коридорт болон бүлэг бүр ангидаа тасалгааны цэцэг тарьж ургуулдаг.
- Сургуулийн хашааны 70 - 80 хувь нь ногоон байгууламжтай. Үүний тал хэсэгт  жимс, жимсгэний модтой болсон6
- Бүлэг бүр хог хаягдлыг ангилан ялгаж, хүүхэд бүрд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал, хэвшлийг эзэмшүүлэхээр ажиллаж байна.
- Эко клубын удирдагч 11а ангийн суралцагч Т.Ганбаяр Монгол улсын 2023 оны “Оны онцлох хүүхэд”-д "Эх орон - Байгальд ээлтэй хүүхэд" номинацид шалгарсан.
- Чиглүүлэгч багш А. Адъяаням Зүүн бүсийн эко клубын “ Шилдэг чиглүүлэгч багш” – аар шалгарсан.











# Хөрөнгө оруулалт

**1**

**Ангийн тохижилт, засвар үйлчилгээ**

" Найнги" сангийн 9300000 төсөвтэй хийгдлээ.

**2**

**" Нэг голын хүүхдүүд" төслийн булан байгуулах**

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалт 2500000

**3**

**" Ухаалаг дэлгэц"**

Хэрлэн сумын ОНХС- ийн хөрөнгө оруулалт 15000000

**<u>Удахгүй хийгдэх хөрөнгө оруулалт"</u>**

"Дэлхийн зөн" ОУБ- аас 6 настны ариун цэврийн өрөө, дотуур байрны ариун цэврийн өрөөний засвар 60 сая төгрөгийн өртөгтэй хийгдэхээр шийдэгдэж, тендэр зарлаад байна.








## Бидний амжилт

**Аймгийн төрөлжсөн олимпиадад:**

5 хичээлээр алт1, мөнгөн медаль 2, хүрэл медаль 3

**Байгаль шинжлэл - 2024 багийн олимпиадад:**

7а ангийн сурагч У. Нэмэхжаргал, М. Мөнхбаатар хүрэл медаль

**ОУ- математикийн Кенгуру олимпиадад:**

8 сурагч 2,3- р зэргийн диплом

**Спортын уралдаан тэмцээнд:**

4 төрлөөр аймаг, улс, бүс, олон улсын тэмцээнээс 10 сурагч алт, мөнгө, хүрэл медаль, Охидын хөлбөмбөгийн баг хүрэл медаль

**Тэтгэлэг:**

12- р ангийн 4 сурагч В. Путины нэрэмжит тэтгэлгээр ОХУ- д суралцах эрх, 1 сурагч ХААИС- д суралцах эрх авсан.

**Үндэсний бичгийн цахим уралдаан, сэтгэх чадварын уралдаан**

Математикийн багш П. Отгонцэцэг аймагт тус бүрд нь “ Тэргүүн байр” эзэлсэн.




















# ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЯ

*Дорнод аймаг Хэрлэн сум 2 дугаар сургууль*

---

*Phone: 86634224*
*Facebook хаяг: Дорнод 2- р сургууль*